

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дугаар зүйл.** Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 5 дахь хэсэг нэмсүгэй:

“5.Засгийн газар эдийн засгийн хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын стратегитай уялдуулан чөлөөт бүс, эдийн засгийн чөлөөт бүс байгуулах, тэдгээрийн дэд бүтэц, удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, төрийн байгууллагын уялдаа холбоог ханган ажиллана.

6.Эдийн засгийн бодлогын хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газар чөлөөт бүс байгуулах, өөрчлөх, татан буулгах, түүний хилийн цэс, байршлыг тогтооно.

**2 дугаар зүйл.** Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.21 дэх заалт, мөн зүйлийн 12.13 дахь заалт, 8.2 дугаар зүйлийн 1.9 дэх заалт, мөн зүйлийн 11.6 дахь хэсэг, “, эсхүл чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагч” гэснийг тус тус хассугай.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2026 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дугаар зүйл.**Зөвшөөрлийн тухай хуулийн 1.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт доор дурдсан агуулгтай 4.10 дахь заалт нэмсүгэй:

“4.10.чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт үйлчлэх тусгай дэглэм, зөвшөөрөл олгохтой холбогдох харилцаа.

**2 дугаар зүйл.**Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.21 дэх заалт, мөн зүйлийн 12.13 дахь заалт, 8.2 дугаар зүйлийн 1.9 дэх заалт, мөн зүйлийн 11.6 дахь хэсэг, “, эсхүл чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагч” гэснийг тус тус хассугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дугаар зүйл.** Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.8 дахь хэсэг нэмсүгэй:

“3.8.Чөлөөт бүс, эдийн засгийн чөлөөт бүс дэх ажиллах хүчний шилжилт хөдөлгөөнтэй холбогдсон харилцаа үйлчлэхгүй.”

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дугаар зүйл.** Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсгийн “, чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагч” гэснийг, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “, чөлөөт бүсэд чөлөөт бүсийн захирагч” гэснийг, 15<sup>1</sup> дүгээр зүйлийн 15<sup>1.1</sup> дэх хэсгийн “, эсхүл чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагчид” гэснийг, 15<sup>1.3</sup> дахь хэсгийн “, эсхүл чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагчийн” гэснийг 15<sup>1.4</sup> дэх хэсгийн “, эсхүл чөлөөт бүсийн захирагч” гэснийг, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “, чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагч,” гэснийг, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн “, чөлөөт бүсийн захирагч” гэснийг, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “, чөлөөт бүсийн захирагч” гэснийг, 35 дугаар зүйлийн 35.1.2 дахь заалтын “, чөлөөт бүсийн захирагч” гэснийг, 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсгийн “чөлөөт бүс,” гэснийг тус тус хассугай.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дугаар зүйл.** Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх хэсгийн “чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагч” гэснийг хассугай.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2026 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ХАРХОРУМ ХОТЫН ТӨЛӨВЛӨЛТ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙГ  
ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дугаар зүйл.** Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “чөлөөт бүс” гэснийг “эдийн засгийн тусгай бүс” гэж өөрчилсүгэй.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2026 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Хот байгуулалтын тухай хуулийн 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.1.8 дахь заалт нэмсүгэй:

“6.1.8.чөлөөт бүс, эдийн засгийн чөлөөт бүсийн хилийн цэс, байршлыг баталж, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах.”

**2 дугаар зүйл.** Хот байгуулалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь заалт, 11.5.1 дэх заалт, 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтын “чөлөөт бүс,” гэснийг, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн “Чөлөөт бүс,” гэснийг тус тус хассугай.

**3 дугаар зүйл.** Хот байгуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ХОТ, ТОСГОНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

